# МОНГОЛ УЛС
# ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 30 өдөр Дугаар А/163 Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29,1-ийн "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Коронавируст халдвар /ковид-19/-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам"-ыг хэрэгжүүлэх зорилгоор Улаанбаатар хотоос тус аймаг руу нэвтрэх иргэдийн ПСР шинжилгээ болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих, Цэнхэрмандал сумын "Дэлүүн болдог" постны үйл ажиллагааг энэ оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл 30 хоногийн хугацаанд ажиллах 12 алба хаагчийн хоол, байрны болон автомашины шатах тослох материалын зардлыг хавсралтаар тус тус батлсугай.

2. Урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж ажиллахад шаардагдах 8.565.000 /найман сая таван зуун жаран таван мянган/ төгрөгийг аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ц.ИДЭРБАТ

231010530

Аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 30 өдрийн А/163 дугаар захирамжийн хавсралт

Хөрөнгө зарцуулалтын тооцоо

| Байгууллагын нэр | ЗАРДЛЫН НЭР ТӨРӨЛ | | | Дүн |
|---|---|---|---|---|
| | Шатахууны зардал | Байрны зардал | Хоолны зардал | |
| Цагдаагийн газар | 465.000 | 900.000 | 7.200.000 | 8.565.000 |
| ДҮН | 465.000 | 900.000 | 7.200.000 | 8.565.000 |